

## **ГАРЧИГ**

### **I. МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН НӨХЦӨЛ**

- I.1. Малчдын тоо, насны бүлэг
- I.2. Малчдын соёл, ахуйн нөхцөл

### **II. МАЛЫН ТОО, БҮТЭЦ**

- II.1. Малын тоо
- II.2. Хувийн /амины/ малын тоо
- II.3. Хээлтэгч мал
- II.4. Төл бойжилт
- II.5. Том малын зүй бус хорогдол
- II.6. Малын хээл хаялт, сувайралт
- II.7. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо
- II.8. Малын хэрэглээний зарлага
- II.9. Сүргийн бүтэц
- II.10. Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал

### **III. МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖ**

- III.1. Бэлчээрийн хүрэлцээ
- III.2. Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж

### **IV. ТЭЖЭЭВЭР АМЬТАД**

### **V. СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

### **VI. ДҮГНЭЛТ, САНАЛ**

## ӨМНӨХ ҮГ

Статистикийн тухай “ Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн газар мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2004 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, дүнг нэгтгэн гаргалаа.

Мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогын 2004 оны дүнд үндэслэсэн энэхүү танилцуулгад малчдын тоо, тэдний соёл, ахуйн нөхцөл, мал, тэжээвэр амьтад, тэжээлийн хүрэлцээ, хангамж зэрэг тооллогын үзүүлэлтүүдийг 2-10 жилийн гүйцэтгэлээр зэрэгцүүлэлт хийж харуулсан.

Танилцуулга нь 6 бүлэг, 48 хавсралтаас бүрдэж байгаа бөгөөд тооллогын дүнг бүсчилсэн байдлаар Баруун, Хангай, Төв, Зүүн бүс болон Улаанбаатар гэсэн ангиллаар зэрэгцүүлэлт хийлээ.

Манай улсын мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга судалгаа суурь материал болно гэдэгт итгэж байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗАР

2005-03-10

## ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

**Малтай өрх.** Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

**Малчин өрх.** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

**Малчид.** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент.

**1 Адуу, үхэр- 1 бод,**

**1 тэмээ -1.5 бод,**

**6 хонь-1 бод**

**8 ямаа –1 бод**

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ-5 хонь

1 адуу- 7 хонь

1 үхэр- 6 хонь

1 хонь -1 хонь

1 ямаа- 0.9 хонь

**Нас гүйцсэн мал.** Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ- 4 настай , 5 ба түүнээс дээш настай

Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

**Өсвөр насны мал .**

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

**Төл мал.** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч.** Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

**Малын тоо, толгойн өсөлт.** Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

**Төллөлтийн хувь.** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлнэ.

**Бойжилтийн хувь.** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100 –гаар үржүүлнэ.

**100 эхээс бойжуулсан төл.** Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25

Азарга - 12-15

Бух - 35-45

Хуц, ухна - 25-30

**Малын зүй бус хорогдолд** өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

**Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь.** Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Малын хэрэглээний зарлага.**

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

**Малын хашааны хангамж.** Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

**Тэжээл хангамж .** Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

**Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент.** Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

Хадлан өвс – 0.45

Таримал тэжээл - 0.35

Даршны ургамал - 0.25

Гар тэжээл, хужир шүү - 1.0

Төмс ногооны хаягдал - 0.22

Үр тарианы хаягдал - 0.9

Лай - 0.4

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

**Малын тэжээлийн ангилал.** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
  1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
  2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
  3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Эдийн засгийн бүсэд:

**Баруун бүсийн аймгууд** – Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан

**Хангайн бүс** – Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг

**Төвийн бүс** - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг

**Зүүн бүс** – Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг

**Улаанбаатар бүс** - Улаанбаатар хот

## I.МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**I.1. Малтай өрх, малчдын тоо.** 2004 онд хувийн малтай 229.4 мянган өрх, үүний дотор 169.0 мянган малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Хувийн малтай өрх нь улсын хэмжээний нийт өрхийн 38.6 хувийг эзэлж байна.

2004 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 369.7 мянган малчид ажиллаж байна. Малтай өрхийн нийт ам бүлийн тоо 929.9 мянга, малчин өрхийн ам бүлийн тоо 678.6 мянга байна.

Малтай өрх болон малчин өрхийн ам бүлийн тоо дунджаар 4 байна.

Малчдын 42.9 хувь нь буюу 158.6 мянга нь эмэгтэй малчид байна.

Насны бүлгээр авч үзвэл 52.2 хувь нь 16-34 насны, 34.5 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 13.3 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. /Зураг 1/

Хүснэгт 1

**Өрх, малчдын тоо, насны бүтэц**

	2000	2001	2002	2003	2004	2004/2003	
						хувь	зөрүү
<b>Малтай өрх, (мян.)</b>	<b>268.7</b>	<b>256.6</b>	<b>243.2</b>	<b>236.2</b>	<b>229.4</b>	<b>97.1</b>	<b>-6.8</b>
<b>Малчин өрх, (мян.)</b>	<b>191.5</b>	<b>185.5</b>	<b>175.9</b>	<b>172.4</b>	<b>169.0</b>	<b>98.0</b>	<b>-3.4</b>
<b>Малчдын тоо (мян.)</b>	<b>421.4</b>	<b>407.0</b>	<b>389.8</b>	<b>377.9</b>	<b>369.7</b>	<b>97.8</b>	<b>-8.3</b>
Үүнээс:16-34 насны	235.7	224.8	210.9	201.8	192.8	95.5	-9.0
35-аас тэтгэвэрт гарах насны	130.3	130.7	128.2	126.6	127.7	100.9	1.1
Тэтгэврийн	55.4	51.5	50.7	49.6	49.1	99.0	-0.5
<b>Нийт малчдаас эмэгтэй</b>	<b>178.5</b>	<b>172.3</b>	<b>165.0</b>	<b>161.0</b>	<b>158.6</b>	<b>98.5</b>	<b>-2.4</b>
<b>Насны бүтэц %</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	-	-
үүнээс: 16-34 насны	55.9	55.2	54.1	53.4	52.2	-	-1.2
35-аас тэтгэвэрт гарах насны	30.9	32.1	32.9	33.5	34.6	-	1.1
Тэтгэврийн	13.2	12.7	13.0	13.1	13.3	-	0.2
<b>Нэг малчин өрхөд ногдох малын тоо</b>	<b>158</b>	<b>141</b>	<b>136</b>	<b>147</b>	<b>166</b>	<b>113</b>	<b>18.8</b>

2004 онд малчин өрхийн тоо 2003 онтой харьцуулахад 3.4 мянгаар, малчдын тоо 8.3 мянгаар буурчээ.

Малчин өрхийн тоо Баян-Өлгий, Баянхонгор, Увс, Говьсүмбэр, Сүхбаатар аймаг, Улаанбаатар хотод өсч, бусад аймгуудад буурч, малчдын тоо Баян-Өлгий, Баянхонгор, Сүхбаатар, Сэлэнгэ, Говьсүмбэр аймагт, Улаанбаатар хотод өсч, бусад аймгуудад буурчээ ( Хавсралт 1, 2 ).


Бүсээр авч үзвэл нийт малчин өрхийн 28.9 хувь Баруун бүсэд, 40.4 хувь нь Хангайн 18.0 хувь нь Төвийн, 11.5 хувь нь Зүүн бүсэд, 1.3 хувь нь Улаанбаатарт байна.

2004 онд 1 малчин өрхөд 166 толгой мал ногдож байгаа нь, 2003 онхоос 19 толгойгоор нэмэгдсэн байна.

Бүсээр авч үзвэл 1 малчин өрхөд ногдох малын тоо Улаанбаатараас бусад бүх бусад өссөн байна. Баруун, Төв, Зүүн бүсийн 1 малчин өрхөд ногдох малын тоо улсын дунджаас дээгүүр, Хангайн бүс, Улаанбаатарт улсын дунджаас доогуур байна.

Зураг 1

Малчдын тоо, мян хүн



**1.2. Малчдын соёл, ахуйн үзүүлэлт.** 2004 оны тооллогоор нийт малчин өрхийн 31.8 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 28.7 хувь нь телевизортой, 12.9 хувь нь автомашинтай, 21.1 хувь нь мотоцикльтай, 1.5 хувь нь трактортой, 63.3 хувь нь малын хашаатай, 16.5 хувь нь худагтай байна.

Сүүлийн 2 жилд хөдөө орон нутагт нарны зайн цахилгааны эх үүсгүүрийн хэрэглээ нэмэгдэж, 2003 оныхоос цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо 24.8 мянгаар буюу 85.8 хувиар, телевизортой өрхийн тоо 15.4 мянгаар буюу 46.4 хувиар тус тус нэмэгдсэн байна. Мөн автомашинтай өрхийн тоо 2003 оныхоос 2.0 мянгаар буюу 10.1 хувиар, мотоцикльтай өрхийн тоо 2.3 мянгаар буюу 6.9 хувиар нэмэгдэв.

Хүснэгт 2


Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд

	Өрхийн тоо, мян.					Малчин өрхийн тоонд эзлэх хувь				
	2000	2001	2002	2003	2004	2000	2001	2002	2003	2004
Цахилгаантай	20.4	24.8	24.1	28.9	53.7	10.6	13.4	13.7	16.7	31.8
Телевизортой	24.6	29.2	29.4	33.2	48.6	12.8	15.8	16.7	19.3	28.7
Автомашинтай	16.6	17.6	18.4	19.8	21.8	8.7	9.5	10.5	11.5	12.9
Мотоцикльтай	31.7	33.9	32.6	33.4	35.7	16.6	18.3	18.6	19.4	21.1
Трактортой	2.8	2.8	2.7	2.7	2.6	1.5	1.5	1.5	1.5	1.5

Аймаг, бүсээр харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 3-д харуулав.

Зураг 2

Малчин өрхийн соёл ахуйн үзүүлэлтүүд, мян.өрх



## II. МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, БҮТЭЦ

**II.1. Малын тоо.** 2004 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 28.0 сая толгойд хүрч, 2003 оныхоос 2.6 саяар буюу 10.2 хувиар өслөө.

Тооллогын дүнгээр тэмээний тоо 256.6 мянга, адуу 2005.3 мянга, үхэр 1841.6 мянга, хонь 11686.4 мянга, ямаа 12238.0 мянгад хүрч, 2003 оныхоос адуу 36.4 мянга, үхэр 48.8 мянга, хонь 930.1 мянга, ямаа 1585.1 мянган толгойгоор тус тус өсч, харин тэмээний тоо 0.1 мянгаар буюу 0.04 хувиар буурав. (Хавсралт 7, 8). 2004 онд 2003 оныхоос 1.4 сая төл илүү бойжуулсан, том малын зүй бус хорогдол 1.0 саяар багассан нь малын тоо өсөхөд голлон нөлөөллөө. 2004 онд 464.1 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 25.2 хувийг эзэлж байна (Хавсралт 35).

Сарлагын тоо 2003 оныхоос 3.6 хувиар буюу 16.2 мянган толгойгоор өссөн байна.

Хүснэгт 5


### Малын тоо, төрлөөр

МЯН.ТОЛ

	2000	2001	2002	2003	2004	2004/2003	
						%	Зөрүү
<b>Бүгд</b>	<b>30227.5</b>	<b>26075.3</b>	<b>23897.6</b>	<b>25427.7</b>	<b>28027.9</b>	<b>110.2</b>	<b>2600.2</b>
Тэмээ	322.9	285.2	253.0	256.7	256.6	99.96	-0.1
Адуу	2660.7	2191.8	1988.9	1968.9	2005.3	101.8	36.4
Үхэр	3097.6	2069.6	1884.3	1792.8	1841.6	102.7	48.8
Хонь	13876.4	11937.3	10636.6	10756.4	11686.4	108.6	930.1
Ямаа	10269.8	9591.3	9134.8	10652.9	12238.0	114.9	1585.1

Гэвч нийт малын өсөлт нь бог малын тооны өсөлтөөр хангагдаж байгаа бөгөөд нийт малын тоо, толгойн өсөлтийн 61.0 хувийг ямаан сүрэг хангаж байна.





Мал тооллогын дүнгээр нийт 19 аймаг Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Дундговь, Өмнөговь, Архангай, Булган, Дорноговь, Төв, Хэнтий, Баян-Өлгий, Дорнод, Говь-Сүмбэр, Орхон, Дархан-Уул аймгууд малаа 2003 онтой харьцуулахад 2.3-22.1 хувиар буюу 2.9-283.9 мянган толгойгоор өсгөсний дотор 7 аймаг Говь-Алтай, Баянхонгор, Увс, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгууд таван төрөл дээр нь өсгөсөн байна. Харин Улаанбаатар хот, Сэлэнгэ, Сүхбаатар аймгуудад малын тоо 2003 оныхоос 1.6-6.9 хувиар буюу 9.5-42.7 мянган толгойгоор буурсан байна.

Нийт малын 30.4 хувь буюу 8524.8 мянга нь Баруун бүсэд, 32.3 хувь буюу 9050.9 мянга нь Хангай бүсэд, 22.3 хувь буюу 6252.8 мянга нь Төвийн бүсэд, 14.2 хувь буюу 3973.2 мянга нь Зүүн бүсэд, 0.8 хувь буюу 226.4 мянга нь Улаанбаатар хотод ногдож байна (Хавсралт 8).


## Малын тоо, бүс нутгаар

Бүс	2000	2001	2002	2003	2004	мян.тол	
						2004/2003	
						%	Зөрүү
Баруун	8702.4	7587.2	6482.2	7410.8	8524.8	115.0	1114.0
Хангай	10711.7	8683.3	7724.6	8131.8	9050.9	111.3	919.1
Төв	6792.6	6003.4	5737.3	5723.7	6252.8	109.2	529.1
Зүүн	3790.1	3579.9	3720.0	3918.2	3973.2	101.4	54.9
УБ	230.6	221.4	233.5	243.3	226.4	93.1	-16.9

2004 онд 2003 оныхоос Баруун бүсийн малын тоо 1114.0 мянгаар буюу 15.0 хувиар, Хангайн бүсийнх 919.1 мянгаар буюу 11.3 хувиар, Төвийн бүсийнх 9.2 хувиар буюу 529.1, Зүүн бүсийнх 55.0 мянгаар буюу 1.4 хувиар тус тус өсч, харин Улаанбаатарынх 16.9 мянгаар буюу 6.9 хувиар буурсан байна. Төвийн бүсийн малын тоо 5 төрөл дээрээ өсчээ. Нийт малын өсөлтийн 42.8 хувь нь Баруун бүсийн, 35.3 хувийг Хангайн бүсийн, 20.3 хувь нь Төвийн бүсийн малын тооны өсөлтөөр хангагдсан байна.

Зураг 4

## Малын тоо, бүс нутгаар



## Малын тооны өсөлт, бууралтад нөлөөлсөн үзүүлэлтүүд

	мян.тол						
	2000	2001	2002	2003	2004	2004/2003	
						%	Зөрүү
Бойжуулсан төл	8273.3	7370.7	6808.7	7885.5	9296.1	117.9	1410.6
100 эхээс бойжуулсан төл	59	56	60	75	86	114.7	11.0
Том малын зүй бус хорогдол	3491.2	4758.9	2917.6	1324.3	291.7	22.0	1032.6
Хээлтэгч малын тоо	13244.3	11386.2	10479.1	10804.8	11604.7	107.4	799.9
Хээл хаясан хээлтэгч	1205.5	1019.9	875.1	523.6	251.8	48.1	-271.8
Сувайрсан хээлтэгч	1494.4	1364.8	1417.6	956.5	700.0	73.2	-256.5

Малын тооны өсөлтөнд 2003 онхоос хээлтэгч мал, бойжсон төл, 100 эхээс бойжуулсан төлийн тоо өмнөх оныхоос нэмэгдэж, том малын хорогдол, хээл хаясан хээлтэгч, сувайрсан малын тоо буурсан нь нөлөөллөө.

## 1995 оноос хойшхи 10 жилийн малын тооны өсөлт, бууралт

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өссөн жилийн тоо	7	2	6	6	5	6
Буурсан жилийн тоо	3	8	4	4	5	4
1995 оноос өссөн хэмжээ, мян.тол	3717.3	-	-	-	-	3717.3
1995 оноос буурсан хэмжээ, мян.тол	-4261.7	-110.9	-643.1	-1475.5	-2032.2	-

1995 оноос хойшхи 10 жилийн 7 жилд нь малын тоо өсч, 3 жилд нь буурчээ. 1995 онтой харьцуулж үзэхэд малын тоо 0.5 саяар буурч, малын төрлөөр авч үзвэл зөвхөн ямааны тоо 3.7 саяар өсч, бусад төрлийн малын тоо 4.3 саяар буурсан байна.

5 төрлийн малын тооны өсөлт бууралтыг 2003 онтой харьцуулан аймгаар авч үзэхэд тэмээ 8 аймагт, адуу 15 аймагт, үхэр 14 аймагт, хонь 19 аймагт, ямаа 20 аймагт тус тус өссөн байна.

2004 оны байдлаар нийт мал сүргийн 84.2 хувийг бог мал, 15.8 хувийг бод мал эзэлж байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг авч үзвэл ямаанаас бусад төрлийн малын эзлэх хувийн жин буурчээ. Жилээс жилд нийт сүрэгт ямааны эзлэх хувийн жин нэмэгдэж, харин тэмээ, адуу, үхэр, хонины эзлэх хувийн жин буурсаар байна.

Хүснэгт 9

**Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь**

	2000	2001	2002	2003	2004
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	1.1	1.1	1.1	1.0	0.9
Адуу	8.8	8.4	8.3	7.7	7.2
Үхэр	10.2	7.9	7.9	7.1	6.6
Хонь	45.9	45.8	44.5	42.3	41.7
Ямаа	34.0	36.8	38.2	41.9	43.7


Бог малын дотор хонь 75.0 хувь, ямаа 25.0 хувь байсан уламжлалт харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээгээр алдагдсаар байна. 2004 оны байдлаар авч үзэхэд бог малын 51.2 хувийг ямаа эзэлж байгаа бог малд ямааны эзлэх хувийн жин жил бүр нэмэгдсээр байна.

Аймгаар авч үзэхэд бог малынх нь 35.6-75.8 хувийг ямаан сүрэг эзэлж байна. Бүсээр авч үзэхэд бог малынх нь 41.3-54.7 хувь нь ямаа сүрэг байна.

Энэ нь мал сүргийн бүтцэд зохисгүй өөрчлөлт гарч байгааг харуулж буй анхаарал татсан асуудал юм. Цаашид ямаан сүргийн тоо толгойн өсөлт үргэлжлэвэл байгаль орчин, бэлчээрийн хүрэлцээнд ямар нөлөөтэйг тогтоож, сүргийн бүтцийн зохистой харьцааг тодорхойлж, энэ талаар мэргэжлийн байгууллагаас асуудал боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Зураг 5

**Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь**




2004 онд улсад нийт мал болон үхрийн тоогоор Хөвсгөл, тэмээгээр Өмнөговь, адуугаар Архангай, хониор Өвөрхангай, ямаагаар Ховд аймаг тэргүүлж байна (Хавсралт 6)

Бүсээр авч үзвэл нийт мал болон адуу, үхэр, хониор Хангайн бүс, ямаагаар Баруун бүс, тэмээгээр Төвийн бүс тэргүүлж байна.

Зураг 6

2004 оны малын тоо, аймгаар



**II.2. Хувийн /амины/ малын тоо.** 2004 онд хувийн малын тоо 27.5 сая толгойд хүрч, нийт малын 98.2 хувийг эзэлж байна. Тэмээний 98.2 хувь, адууны 98.4, үхрийн 98.7, хонины 97.4, ямааны 98.9 хувь нь хувийн аж ахуйд байна (Хавсралт 10,11, 13). Хувийн малын тоо 2003 оныхоос 2628.7 мянгаар буюу 10.6 хувиар өслөө.

Хүснэгт 10

Хувийн малтай өрх, малын тоо

МЯН.ТОЛ

	Малтай өрхийн тоо, мян.өрх	Бүгд	үүнээс				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1990	262.3	8242.9	88.2	1108.1	1457.5	3684.7	1904.4
1991	288.9	14002.6	186.3	1492.1	1896.6	7209.4	3218.2
1992	301.5	18081.1	253.7	1728.0	2237.4	9589.1	4272.9
1993	289.7	22565.2	335.0	2026.8	2503.5	11902.0	5797.9
1994	289.2	24527.2	343.3	2279.0	2811.8	12133.8	6959.3
1995	283.9	26447.2	349.7	2532.0	3140.4	12194.1	8231.0
1996	278.3	27365.2	342.6	2670.6	3323.4	12184.6	8844.0
1997	279.7	29529.0	343.8	2807.4	3485.4	12912.0	9980.5
1998	275.0	31356.3	346.4	2982.6	3613.5	13630.1	10783.8
1999	270.0	32278.7	346.4	3097.3	3733.2	14306.5	10795.3
2000	268.7	29236.7	315.5	2609.4	3028.3	13206.0	10077.5
2001	256.6	25335.6	278.3	2152.4	2031.8	11439.0	9434.2
2002	243.2	23280.0	247.2	1953.0	1853.4	10232.4	8994.1
2003	236.2	24888.8	251.8	1937.5	1768.3	10417.6	10513.5
2004	229.4	27517.5	252.1	1973.4	1817.0	11376.9	12098.1

2004 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 44.0 хувийг ямаа, 41.3 хувийг хонь, 7.2 хувийг адуу, 6.6 хувийг үхэр, 0.9 хувийг тэмээ эзэлж байна.

2004 оны эцэс дэх иргэдийн хувийн малын бүлэглэлтээс авч үзвэл 2003 оныхоос 100 хүртэл толгой малтай өрхийн тоо буурч, бусад бүлгийн малтай өрхийн тоо өсчээ.

2004 онд нийт малтай өрхөд 100 хүртэл толгой малтай өрхийн эзлэх хувийн жин 61.1 хувь болж, 2003 оныхоос 4.0 пунктээр буурч, харин түүнээс дээшхи бүлгийн малтай өрхийн эзлэх хувийн жин 38.9 хувь болж, 4.03 пунктээр нэмэгдсэн байна.

2004 оны байдлаар малтай өрхийн 61.1 хувь нь 100 хүртэл толгой малтай, 20.9 хувь нь 101-200 толгой малтай байна, өөрөөр хэлбэл малтай нийт өрхийн 82.0 хувь нь 200 хүртэл толгой малтай байна. Энэ үзүүлэлт 2003 онд 85.5 хувь байлаа.

Хүснэгт 11

### Малтай өрхийн малын бүлэглэлт

	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо, мян.тол	
	2003	2004	2003	2004	2003	2004
<b>2004 Дүн</b>	<b>236210</b>	<b>229437</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>24888.6</b>	<b>27517.4</b>
100 хүртэл малтай	154505	140095	65.4	61.1	6181.3	5639.1
101-200 малтай	47393	47946	20.1	20.9	6713.8	6772.1
201-500 малтай	29669	34941	12.6	15.2	8594.4	10344.8
501-999 малтай	3870	5367	1.6	2.3	2454.8	3422.9
1000-1499 малтай	684	943	0.3	0.4	777.0	1066.7
1500-2000 малтай	61	98	0.03	0.04	102.7	164.7
2001-ээс дээш малтай	28	47	0.01	0.02	64.6	107.1

Аймгаар авч үзэхэд 200 хүртэл толгой малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 63.0-97.7 хувьтай байна. Бүсээр авч үзвэл энэ үзүүлэлт Баруун бүсэд 80.5, Хангай бүсэд 85.4, Төвийн бүсэд 77.9 хувь, Зүүн бүсэд 77.7 хувь, Улаанбаатарт 97.7 хувь байна.

1000 ба түүнээс дээш малтай 1088 өрх тоологдсон нь 2003 оныхоос 315 өрхөөр илүү байна. 1000-аас дээш малтай өрхийн 32.4 хувь нь Баруун бүсэд, 26.9 хувь нь Зүүн бүсэд, 20.4 хувь нь Хангайн бүсэд, 20.1 хувь нь Төвийн бүсэд ногдож байна.

1000-аас дээш малтай өрхийн тоогоор Хэнтий аймаг тэргүүлж, удаахь байранд Сүхбаатар аймаг орж байна (Хавсралт 5)

Малтай 1 өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр

	2002	2003	2004					
			бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
<b>Дүн</b>	<b>96</b>	<b>105</b>	<b>121</b>	<b>1</b>	<b>9</b>	<b>8</b>	<b>50</b>	<b>53</b>
10 хүртэл малтай	6	5	6	0	1	3	1	1
11-30 малтай	21	20	21	0	3	4	5	9
31-50 малтай	40	41	40	0	4	5	12	19
51-100 малтай	73	74	74	1	6	6	25	36
101-200 малтай	142	142	141	1	10	9	54	67
201-500 малтай	291	290	296	3	19	14	130	130
501-999 малтай	643	634	638	6	42	29	323	238
1000-1499 малтай	1139	1136	1132	7	72	50	638	365
1500-2000 малтай	1707	1683	1680	13	108	64	973	522
2001-ээс малтай дээш	2389	2307	2278	12	159	116	1346	645

Улсын дунджаар хувийн малтай нэг өрхөд 121 толгой мал ногдож байгаа нь 2003 оныхоос 16 малаар илүү байна. Малтай 1 өрхөд тэмээ 1, адуу 9, үхэр 8, хонь 50, ямаа 53 ногдож байна.

200 хүртэл толгой малтай нэг өрхөд дунджаар 66 толгой, 201-999 малтай 1 өрхөд 342 толгой, 1000 ба түүнээс дээш малтай өрхөд 1230 толгой мал тус тус ногдож байна.

Малтай нэг өрх дунджаар 4 ам бүлтэй байгаа бөгөөд 1 хүнд бодод шилжүүлснээр 8, толгойн тоогоор 30 мал ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо (толгойгоор) бүх аймгуудад 2003 оныхос нэмэгдэж, харин Улаанбаатар хотод буурсан байна.

2004 онд малтай өрхөд нэг ногдох хувийн малын тоо Улаанбаатараас бусад бүх бүсэд 2003 оныхоос 6-22 толгойгоор нэмэгдсэн байна. Зүүн, Төв, Баруун бүсийн малтай нэг өрхөд улсын дунджаас дээгүүр буюу 6-22 толгойгоор илүү мал ногдож байна (Хавсралт 12).

**II.3 Хээлтэгч мал.** 2004 оны эцэст 11604.7 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь 2003 оныхоос 800.0 мянган толгойгоор нэмэгдсэний дотор ингэ 0.3 мянгаар, гүү 8.4 мянгаар буурч, үнээ 11.9 мянга, 294.4 мянга, ямаа 502.4 мянган толгойгоор тус тус өссөн байна. (Хавсралт 21).

## Хээлтэгч малын тоо


МЯН.ТОЛ

	2000	2001	2002	2003	2004	2004/2003	
						%	Зөрүү
<b>Бүгд</b>	<b>13244.3</b>	<b>11386.2</b>	<b>10479.1</b>	<b>10804.8</b>	<b>11604.7</b>	<b>107.4</b>	<b>799.9</b>
Тэмээ	94.8	85.3	75.2	77.7	77.4	99.6	-0.3
Адуу	823.1	692.1	594.7	580.2	571.8	98.5	-8.4
Үхэр	1214.3	850.8	773.8	721.4	733.3	101.7	11.9
Хонь	6417.9	5438.5	4861.4	4853.2	5147.5	106.1	294.4
Ямаа	4694.3	4319.5	4174.1	4572.4	5074.8	111.0	502.4

Хээлтэгч мал нийт малын 41.4 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 30.2 хувь, адуун сүргийн 28.5 хувь, үхэр сүргийн 39.8 хувь, хонин сүргийн 44.0 хувь, ямаан сүргийн 41.5 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 7

## Хээлтэгч малын тоо



Аймгаар авч үзвэл хээлтэгч малын тоо нь Дархан-Уул, Сэлэнгэ, Баян-Өлгий, Сүхбаатар аймаг, Улаанбаатар хотод 2.3-27.3 мянгаар толгойгоор буурч, бусад аймгуудад 9.6-110.7 мянган толгойгоор нэмэгджээ (Хавсралт 23).

Бүсээр авч үзвэл Улаанбаатараас бусад бүсийн хээлтэгч малын тоо 0.6-12.1 хувиар буюу 10.1-377.0 мянгаар өссөн байна. Баруун бүсийн нийт малын 40.9 хувь, Хангайн бүсийн нийт малын 40.9 хувь, Төвийн бүсийн нийт малын 41.5 хувь, Зүүн бүсийн нийт малын 43.1 хувь, Улаанбаатар хотын нийт малын 47.5 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

**II.4 Төл бойжилт.** 2004 онд гарсан төлийн 97.2 хувийг буюу 9296.1 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2003 оныхоос 1410.6 мянган толгойгоор, бойжилтын хувь 3.8 пунктээр нэмэгдсэн байна. Гарсан ботгоны 95.1 хувь, унаганы



94.0 хувь, тугалны 97.1 хувь, хурга, ишигний 97.4 хувийг бойжуулсан байна. Бойжуулсан төл бүх төрөл дээрээ өсөв.

Хүснэгт 14

### Төл бойжилт


мян.тол

	Бүгд			үүнээс				
	2002	2003	2004	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	7756.0	8441.0	9562.8	37.7	408.6	565.4	4363.4	4187.7
Бойжсон төл	6808.7	7885.5	9296.1	35.8	384.1	549	4250.4	4076.8
Бойжилтийн хувь	87.8	93.4	97.2	95.1	94.0	97.1	97.4	97.4

2004 онд бойжуулсан төлийн тоо Орхоноос бусад бүх аймагт 1.8-50.3 хувь буюу 5.1-132.5 мянган толгойгоор өссөн дүн гарлаа. (Хавсралт 24).

Зураг 8

### Бойжуулсан төлийн тоо



Бойжуулсан төлийг бүсээр авч үзвэл бүх бүсэд бойжуулсан төлийн тоо нэмэгджээ. Баруун бүсэд гарсан төлийн 97.2 хувь, Хангайн бүсэд 97.4 хувь, Төвийн бүсэд 97.4 хувь, Зүүн бүсэд 96.3 хувийг, Улаанбаатар хотод 98.3 хувийг бойжуулсан байна.

Нийт бойжуулсан төлийн 31.1 хувь нь Баруун бүсэд, 31.4 хувь нь Хангайн бүсэд, 22.3 хувь нь Төвийн бүсэд, 14.2 хувь нь Зүүн бүсэд, 1.0 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

## Бойжуулсан төл


МЯН.ТОЛ

	2000	2001	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>8273.3</b>	<b>7370.7</b>	<b>6808.7</b>	<b>7885.5</b>	<b>9296.1</b>
Тэмээ	32.6	28.2	25.1	31.7	35.8
Адуу	368.8	308.8	318.0	306.3	384.1
Үхэр	790.3	539.4	513.5	512.8	549.0
Хонь	4412.7	3967.0	3612.5	3761.0	4250.4
Ямаа	2668.9	2527.4	2339.6	3273.7	4076.8

Улсын дунджаар 100 эхээс 86 төл бойжуулсан байна. 100 эхээс бойжуулсан төлийн тоо 2003 оныхоос бүх төрөл дээрээ 4-14 төлөөр нэмэгджээ. Сүхбаатар, Говьсүмбэр аймгаас бусад бүх аймагт 100 эхээс бойжуулсан төлийн тоо өсөв. (Хавсралт 25).

Зураг 9

## 100 эхээс бойжуулсан төл



Бүсээр авч үзвэл Баруун, Хангай, Төвийн бүс болон Улаанбаатар хотод 100 эхээс бойжуулсан төлийн тоо 2003 оныхоос 9-17 толгойгоор нэмэгдэж, харин Зүүн бүсэд өмнөх оны түвшинд байна. Харин Баруун бүсэд 100 эхээс бойжуулсан төлийн тоо улсын дунджаас 7 төлөөр дээгүүр, Төвийн болон Зүүн бүс, Улаанбаатар хотод 2-9 төлөөр доогуур байна.

Хүснэгт 16

## 100 эхээс бойжуулсан төл

	2000	2001	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>59</b>	<b>56</b>	<b>60</b>	<b>75</b>	<b>86</b>
Тэмээ	32	30	30	42	46
Адуу	40	38	46	52	66
Үхэр	55	44	60	66	76
Хонь	65	62	66	77	88
Ямаа	55	54	54	78	89

**II.5 Том малын зүй бус хорогдол.** 2004 онд оны эхний нийт малын 1.1 хувьтай тэнцэх 291.7 мянган толгой мал хорогдсон нь 2003 оныхоос 1.0 саяар буюу 78.0 хувиар буурсан байна. 2004 онд байгаль, цаг уурын байдал харьцангуй сайн байснаас зүй бусын хорогдол бага гарч, мал өсөхөд эерэг нөлөө үзүүллээ. 2003 онтой харьцуулахад малын хорогдол 5 төрөл дээрээ буурчээ. Нийт хорогдсон малын 39.8 хувийг хонь, 33.0 хувийг ямаа, 15.8 хувийг үхэр, 10.6 хувийг адуу, 0.8 хувийг тэмээ эзэлж байна.

Хүснэгт 17

**Том малын зүй бус хорогдол**


МЯН.ТОЛ

	2000	2001	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>3491.2</b>	<b>4758.9</b>	<b>2917.6</b>	<b>1324.3</b>	<b>291.7</b>
Тэмээ	18.5	20.5	25.7	7.3	2.4
Адуу	393.9	449.8	213.4	136.7	31.0
Үхэр	630.5	1018.5	196.4	215.4	46.0
Хонь	1416.9	1988.2	1174	536.6	116.0
Ямаа	1031.4	1282	1308.1	428.4	96.3

Том малын хорогдол Говьсүмбэрээс бусад бүх аймагт 2003 оныхоос 3.7-283.8 мянган толгойгоор буурч, Говьсүмбэр аймагт 0.1 мянган толгойгоор нэмэгдсэн байна (Хавсралт 26).

Зураг 10

**Том малын зүй бус хорогдол**



Бүсээр авч үзвэл бүх бүсэд хорогдлын хэмжээ 33.1-85.8 хувиар буюу 3.7-493.6 мянган толгойгоор буурсан байна. Нийт хорогдлын 31.4 хувь нь Зүүн бүсэд, 28.1 хувь нь Хангайн бүсэд, 21.3 хувь нь Төвийн бүсэд, 18.0 хувь Баруун бүсэд ногдож байна.

## Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2000	2001	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>10.4</b>	<b>15.7</b>	<b>11.2</b>	<b>5.5</b>	<b>1.1</b>
Тэмээ	5.2	6.3	9.0	2.9	1.0
Адуу	12.5	16.9	9.7	6.9	1.6
Үхэр	16.5	32.9	9.5	11.4	2.6
Хонь	9.3	14.3	9.8	5.0	1.1
Ямаа	9.3	12.5	13.6	4.7	0.9

2004 онд 39.6 мянган мал гэнэтийн аюулаар хорогдсон нь 2002 оныхоос 603.7 мянган толгойгоор буюу 93.8 хувиар буурчээ (Хавсралт 26а).

Нийт хорогдлын 13.6 хувь буюу 39.6 мянга нь гэнэтийн аюулаар, 86.4 хувь буюу 252.1 мянган нь өвчнөөр болон бусад шалтгаанаар хорогджээ. Гэнэтийн аюулаар хорогдсон малын 45.2 хувь нь Төвийн бүсэд, 26.8 хувь нь Баруун бүсэд байна.

## Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо

	2000	2001	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>1738.7</b>	<b>2694.0</b>	<b>1630.2</b>	<b>643.3</b>	<b>39.6</b>
Тэмээ	7.9	6.3	12.4	1.1	0.2
Адуу	214.0	261.1	97.9	65.9	3.4
Үхэр	299.4	585.9	82.9	107.6	4.6
Хонь	704.9	1158.5	655.9	267.9	17.3
Ямаа	512.5	682.2	781.1	200.9	14.2

мян.тол

**II.6. Малын хээл хаялт, сувайралт.** 2004 онд оны эхний хээлтэгч малын 8.8 хувьтай тэнцэх 1.0 сая мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 2003 оныхоос 35.7 хувиар буюу 528.3 мянгаар буурчээ. Сувайрсан болон хээл хаясан малын тоо буурсан нь төл малын тоог нэмэгдүүлж, малын тоо толгой өсөхөд сайн нөлөө үзүүлээ.

Төл өгөөгүй хээлтэгч малын 73.5 хувь буюу 700.1 мянга нь сувайрсан хээлтэгч, 26.5 хувь буюу 251.8 мянга нь хээл хаясан хээлтэгч байна.

## Хээл хаяж, сувайрсан эх малын тоо

МЯН.ТОЛ

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2002	2003	2004	2002	2003	2004	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>2292.8</b>	<b>1480.1</b>	<b>951.8</b>	<b>1417.6</b>	<b>956.5</b>	<b>700.1</b>	<b>875.1</b>	<b>523.6</b>	<b>251.8</b>
Ингэ	11.3	5.7	3.4	9.0	4.7	2.9	2.2	0.9	0.5
Гүү	224.1	184.3	128.9	154.0	125.7	99.3	70.1	58.7	29.7
Үнээ	210.0	161.6	119.3	156.4	118.8	93.7	53.6	42.8	25.6
Эм хонь	752.8	547.5	351.5	542.1	377.1	260.7	210.7	170.3	90.8
Эм ямаа	1094.6	581.1	348.7	556.1	330.2	243.5	538.5	250.9	105.2

Аймгаар авч үзвэл Баян-Өлгий, Сүхбаатар аймагт төл өгөөгүй хээлтэгч малын тоо 6.1-6.8 мянгаар нэмэгдэж, бусад аймгуудад 0.4-101.9 мянгаар буурсан байна (Хавсралт 27, 28, 29).

Хүснэгт 21


## Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2002	2003	2004	2002	2003	2004	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>20.1</b>	<b>14.1</b>	<b>8.8</b>	<b>12.5</b>	<b>9.1</b>	<b>6.5</b>	<b>7.7</b>	<b>5.0</b>	<b>2.3</b>
Ингэ	13.2	7.5	4.4	10.6	6.3	3.7	2.6	1.2	0.6
Гүү	32.4	31.0	22.2	22.2	21.1	17.1	10.1	9.9	5.1
Үнээ	24.7	20.9	16.5	18.4	15.3	13.0	6.3	5.5	3.6
Эм хонь	13.8	11.3	7.2	10.0	7.8	5.4	3.9	3.5	1.9
Эм ямаа	25.3	13.9	7.6	12.9	7.9	5.3	12.5	6.0	2.3

Хээл хаяж, сувайрсан эх малын 38.6 хувь нь Хангайн, 23.9 хувь нь Төвийн, 15.7 хувь нь Баруун, 20.3 хувь нь Зүүн бүсэд, 1.4 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Зураг 11

## Хээл хаялт, сувайралт



**II.7. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.** Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна.

2004 онд 296.1 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2003 оныхоос 0.2 мянган толгойгоор буюу 0.1 хувиар өссөн байна. Буур, азарга, бухны тоо 2003 оныхоос 0.3-3.7 мянгаар буурч, харин хуц, ухны тоо 0.3-4.4 мянгаар нэмэгджээ.

Хүснэгт 22

**Хээлтүүлэгч малын тоо**

мян.тол

	Хээлтүүлэгч мал-бүгд					Үүнээс: шинээр тавьсан				
	2000	2001	2002	2003	2004	2000	2001	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>317.5</b>	<b>279.7</b>	<b>276.0</b>	<b>295.9</b>	<b>296.1</b>	<b>6.7</b>	<b>12.5</b>	<b>13.5</b>	<b>12.2</b>	<b>7.6</b>
Буур	4.4	3.9	3.7	3.8	3.5	0.0	0.0	0.1	0.1	0.1
Азарга	112.6	99.7	91.2	89.5	85.8	0.8	0.8	1.2	1.0	0.7
Бух	43.5	28.5	26.9	26.5	26.0	1.0	0.8	1.3	1.0	0.6
Хуц	90.2	83.4	82.8	91.0	91.3	2.9	6.5	5.8	5.3	3.3
Ухна	66.8	64.2	71.4	85.1	89.5	2.0	4.4	5.1	4.8	2.9

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой атал 2004 онд улсын дунджаар 53 эм хонь, 51 эм ямаа ногдож, 2 дахин өндөр үзүүлэлт гарч байна (Хавсралт 30).

Хүснэгт 23

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо**

	Үржлийн норм	2000	2001	2002	2003	2004
Ингэ	20-25	22	22	21	21	22
Гүү	12-15	7	7	7	7	7
Үнээ	35-45	28	30	29	27	28
Эм хонь	25-30	71	65	59	53	53
Эм ямаа	25-30	70	67	59	54	51

**II.8. Малын хэрэглээний зарлага.** 2004 онд оны эхний нийт малын 25.2 хувьтай тэнцэх 6404.9 мянган малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2003 оныхоос 1370.4 мянган толгойгоор өслөө. Хэрэглээнд зарцуулсан малын тоо 5 төрөл дээр өссөн байна. (Хавсралт 33, 34).

Малтай нэг өрх дунджаар 28 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан байна. Үүнийг улсын хэмжээний нийт өрхөөр тооцвол нэг өрх дунджаар 11 толгой мал буюу 3 бодыг хэрэглээндээ зарцуулсан байна.

**Малын хэрэглээний зарлага**

	МЯН.ТОЛ				
	2000	2001	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>8119.3</b>	<b>6763.4</b>	<b>6076.1</b>	<b>5034.5</b>	<b>6404.9</b>
Тэмээ	47.1	45.4	31.8	20.7	33.3
Адуу	477.9	327.9	314.2	193.6	317.6
Үхэр	886.6	549.6	502.5	388.7	454.2
Хонь	4306.2	3916.5	3739.6	3104.4	3204.3
Ямаа	2401.5	1924	1488	1327.1	2395.5
	Оны эхний малд эзлэх хувь				
<b>Бүгд</b>	<b>26.6</b>	<b>24.2</b>	<b>23.3</b>	<b>21.1</b>	<b>25.2</b>
Тэмээ	9.0	13.1	11.1	8.2	13.0
Адуу	11.5	15.1	14.3	9.7	16.1
Үхэр	21.7	23.2	24.3	20.6	25.3
Хонь	29.9	28.3	31.3	29.2	29.8
Ямаа	28.5	21.8	15.5	14.5	22.5

Хэрэглээнд зарцуулсан малын 87.4 хувийг бог мал, 12,6 хувийг бод мал эзэлж байгаа бөгөөд оны эхний тэмээний 13.0 хувь, адууны 16.1 хувь, үхрийн 25.3 хувь, хонины 29.8 хувь, ямааны 22.5 хувийг хэрэглээнд зарцуулсан байна.

Хүснэгт 25

**Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод  
хэрэглэсэн малын тоо**

	Зах зээлд худалдан борлуулсан					Аж ахуйн дотоодод хэрэглэсэн				
	2000	2001	2002	2003	2004	2000	2001	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>2389.4</b>	<b>2141.4</b>	<b>2181.5</b>	<b>1828.3</b>	<b>2230.2</b>	<b>3803.7</b>	<b>3610.8</b>	<b>2977.8</b>	<b>2597.7</b>	<b>2877.6</b>
Тэмээ	8.8	10.7	8.3	7.9	10.9	18.4	21.1	17.1	12.0	12.8
Адуу	125.4	105.9	124.3	81.9	120.5	176.7	161.4	140.9	112.1	129.1
Үхэр	302.9	189.1	192.5	152.9	180.6	365.5	283.3	232.8	195.1	187.0
Хонь	1309.6	1270.4	1358.6	1093.1	1110.6	1988.7	1937.4	1646.1	1410.4	1364.6
Ямаа	642.7	565.3	497.8	492.4	807.6	1254.4	1207.6	940.9	868.1	1184.1

Хэрэглээнд зарцуулсан малын 34.8 хувийг зах зээлд худалдан борлуулж, 44.9 хувийг аж ахуйн дотоод хэрэгцээнд зарцуулсан байна.


Бүсээр авч үзвэл Баруун бүсэд оны эхний малынхаа 23.3 Хангайн бүсэд 23.6 хувь, Төвийн бүсэд 25.9 хувь, Зүүн бүсэд 29.8 хувь, Улаанбаатард 46.0 хувийг тус тус хэрэглээнд зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 26.9 хувь нь Баруун, 30.0 хувь нь Хангайн бүсэд, 23.1 хувь нь Төвийн бүсэд, 18.3 хувь нь Зүүн бүсэд, 1.7 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

Малтай нэг өрх дунджаар 10 толгой малыг зах зээлд борлуулж, 13 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

Зураг 12

Малын хэрэглээний зарлага



**II.9. Сүргийн бүтэц.** 2004 оны байдлаар нийт сүргийн 34.8 буюу 9752.5 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 22.7 хувь буюу 6374.4 мянган толгой нь нас гүйцсэн мал, 41.4 хувь буюу 11604.8 мянган толгой нь хээлтэгч мал, 1.1 хувь буюу 296.1 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна.

Хүснэгт 26

2004 оны сүргийн бүтэц

	Толгойгоор, мян.тол					Хувиар				
	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч
<b>Бүгд</b>	<b>28027.9</b>	<b>9752.5</b>	<b>6374.4</b>	<b>11604.8</b>	<b>296.1</b>	<b>100.0</b>	<b>34.8</b>	<b>22.7</b>	<b>41.4</b>	<b>1.1</b>
Тэмээ	256.6	82.2	93.5	77.4	3.5	100.0	32.0	36.4	30.2	1.4
Адуу	2005.3	688.7	659.0	571.8	85.8	100.0	34.3	32.9	28.5	4.3
Үхэр	1841.6	848.4	233.9	733.3	26.0	100.0	46.1	12.7	39.8	1.4
Хонь	11686.4	4118.4	2329.1	5147.5	91.3	100.0	35.2	19.9	44.0	0.8
Ямаа	12238.0	4014.8	3058.9	5074.8	89.5	100.0	32.8	25.0	41.5	0.7

2003 оныхоос төл өсвөр насны малын нийт сүрэгт эзлэх хувийн жин өсч, нас гүйцсэн мал, хээлтэгч малынх буурч, хээлтүүлэгч малынх 2003 оныхоо түвшинд байна.



## Сүргийн бүтэц, хувиар

	Төл, өсвөр насны					Нас гүйцсэн эр				
	2000	2001	2002	2003	2004	2000	2001	2002	2003	2004
Бүгд	29.9	30	30.1	32.9	34.8	25.3	25.3	24.9	23.5	22.7
Тэмээ	25.5	23.9	25.3	27.6	32.0	43.8	44.9	43.6	40.7	36.4
Адуу	27.7	25.3	30.4	31.1	34.3	37.1	38.5	35.1	34.9	32.9
Үхэр	43.8	41.5	43.3	44.8	46.1	15.6	16.1	14.2	13.5	12.7
Хонь	30.8	32.2	32.1	33.8	35.2	22.3	21.5	21.4	20.2	19.9
Ямаа	25.1	26	25.2	30.4	32.8	28.5	28.3	28.3	25.9	25.0


үргэлжлэл

	Хээлтэгч					Хээлтүүлэгч				
	2000	2001	2002	2003	2004	2000	2001	2002	2003	2004
Бүгд	43.8	43.7	43.9	42.5	41.4	1.1	1.1	1.2	1.2	1.1
Тэмээ	29.3	29.9	29.7	30.3	30.2	1.4	1.4	1.5	1.5	1.4
Адуу	30.9	31.6	29.9	29.5	28.5	4.2	4.6	4.6	4.5	4.3
Үхэр	39.2	41.1	41.1	40.2	39.8	1.4	1.4	1.4	1.5	1.4
Хонь	46.3	45.6	45.7	45.1	44.0	0.6	0.7	0.8	0.8	0.8
Ямаа	45.7	45	45.7	42.9	41.5	0.7	0.7	0.8	0.8	0.7

Төл, өсвөр насны малын нийт сүрэгт эзлэх хувийн жин 2003 онтой харьцуулахад 5 төрөл дээрээ өсч, харин нас гүйцсэн мал, хээлтэгч, хээлтүүлэгчийнх буурсан байна.

Зураг 13

## Сүргийн бүтэц, хувиар



**II.10 Цэвэр үүлдэр болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.** 2004 оны эцэст цэвэр үүлдрийн 1211.3 мянган мал, эрлийз 450.4 мянга, сайжруулсан нутгийн үүлдрийн 1177.5 мянган мал, нутгийн шилмэл омгийн 708.4 мянган мал тоологдов.

Цэвэр үүлдрийн мал 2003 оныхоос 4.3 хувиар буюу 50.3 мянган тлгойгоор, эрлийз мал 18.4 хувиар буюу 70.0 мянган толгойгоор, нутгийн шилдэг омгийн мал

23.7 хувиар буюу 135.6 мянган толгойгоор, сайжруулсан нутгийн үүлдрийн мал 5.9 хувиар буюу 66.0 мянган толгойгоор тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 27

**Цэвэр болон эрлийз нутгийн шилдэг омгийн малын тоо**

мян.тол

	2000	2001	2002	2003	2004	2004/2003	
						%	зөрүү
<b>Цэвэр үүлдрийн мал</b>	<b>731.5</b>	<b>722.3</b>	<b>645.9</b>	<b>1161.0</b>	<b>1211.3</b>	<b>104.3</b>	<b>50.3</b>
Үхэр	29.1	27.4	25.3	15.7	26.5	168.8	10.8
Хонь	588.5	572.2	504.2	975.3	1013.1	103.9	37.8
Ямаа	113.9	122.7	116.4	170.0	171.7	101.0	1.7
<b>Эрлийз мал</b>	<b>1109.3</b>	<b>963.2</b>	<b>937.5</b>	<b>380.4</b>	<b>450.4</b>	<b>118.4</b>	<b>70.0</b>
Үхэр	106.1	94.4	91.6	57.9	53.5	92.3	-4.4
Хонь	760.1	594.2	545.5	68.1	73.7	108.2	5.6
Ямаа	243.1	274.6	300.4	254.4	323.2	127.0	68.8
<b>Нутгийн шилдэг омгийн мал</b>	<b>791.0</b>	<b>1097.4</b>	<b>1152.4</b>	<b>572.8</b>	<b>708.4</b>	<b>123.7</b>	<b>135.6</b>
Үхэр	4.4	0.6	3.8	2.5	0.7	28.0	-1.8
Хонь	468.4	523.5	564.7	65.5	81.6	124.6	16.1
Ямаа	282	544.1	542.4	480.6	599.4	124.7	118.8
Тэмээ	3.3	5.0	5.2	5.2	5.3	101.9	0.1
Адуу	32.9	24.2	36.3	19.0	21.4	112.6	2.4
<b>Сайжруулсан нутгийн үүлдрийн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1111.5</b>	<b>1177.5</b>	<b>105.9</b>	<b>66.0</b>
Тэмээ	-	-	-	0.5	0.7	135.8	0.2
Адуу	-	-	-	10.2	12.6	123.6	2.4
Үхэр	-	-	-	21.8	23.2	106.4	1.4
Хонь	-	-	-	738.8	719.0	97.3	-19.8
Ямаа	-	-	-	340.2	422.0	124.0	81.8

2003 оны мал тооллогоор манай улсад өсгөн үржүүлж байгаа үүлдрийн болон шилдэг омгийн малын талаар ХХААЯ-наас шинэчлэн баталж ирүүлсэн жагсаалтыг үндэслэн үүлдрийн болон шилдэг омгийн мал, түүгээр сайжруулсан нутгийн үүлдрийн малын ангилалд зохих ёсоор өөрчлөлт оруулсан. Үүний дагуу дээрхи 4 ангилалаар малын тоог гаргалаа.

Энэхүү ангиллын дагуу дүнг нэгтгэн гаргахад цэвэр үүлдрийн мал нийт малын 4.3 хувийг, эрлийз үүлдрийн мал 1.6 хувийг, нутгийн шилдэг омгийн мал 2.5 хувийг, сайжруулсан нутгийн үүлдрийн мал 4.2 хувийг тус тус эзэлж байна (Хавсралт 31, 32)

Тэмээн сүргийн 2.1 хувь нь нутгийн шилдэг омог, 0.3 хувь нь сайжруулсан нутгийн үүлдэр, адуун сүргийн 1.1 хувь нь нутгийн шилдэг омгийн, 0.6 хувь нь сайжруулсан нутгийн үүлдрийн, үхэр сүргийн 1.4 хувь нь цэвэр үүлдрийн, 2.9 хувь нь эрлийз үүлдрийн, 0.04 хувь нь нутгийн шилдэг омгийн, 1.3 хувь нь сайжруулсан нутгийн үүлдрийн, хонин сүргийн 8.7 хувь нь цэвэр үүлдрийн, 0.6 хувь нь эрлийз, 0.7 хувь нь нутгийн шилдэг омгийн, 6.2 хувь нь сайжруулсан, ямаан сүргийн 1.4 хувь нь

цэвэр үүлдрийн, 2.6 хувь нь эрлийз, 4.9 хувь нь нутгийн шилдэг омгийн, 3.4 хувь нь сайжруулсан нутгийн үүлдрийн мал байна.

### III.МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖ

**III.1 . Бэлчээрийн хүрэлцээ.** Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2004 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар манай улсын бэлчээр хадлангийн талбай 112.8 сая га талбайд хүрч, 2003 оныхоос 0.3 сая га-гаар буюу 0.2 хувиар буурсан байна. 2004 онд малын тоо хонин толгойд шилжүүлснээр 49.1 сая толгойд хүрч 2003 оныхоос 2.9 саяар өсчээ.

2004 онд 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 44 толгой мал ногдож байна.


Хүснэгт 28

#### Бэлчээрийн хүрэлцээ хангамж

	2000	2001	2002	2003	2004	$\frac{2004}{2003}$ %
Хадлан бэлчээрийн талбай, мян.га	129393.4	128943.6	128937.1	113089.9	112823.7	99.8
100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо	48	39	35	41	44	107.3

100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 2003 оныхоос 3 толгойгоор нэмэгджээ.

100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо



2004 онд 100 га талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо хүн амын шилжилт хөдөлгөөн харьцангуй их байгаа аймаг, хот болон малын тоогоор улсад тэргүүлдэг зарим аймагт өндөр байна. Орхон аймагт 550 толгой, Улаанбаатарт 203 толгой, Дархан-Уул аймагт 129 толгой, мөн малын тоогоор улсад дээгүүрт ордог Архангай аймагт 110 толгой, Хөвсгөл аймагт 107 толгой тус тус ногдож байна. Энэ нь бэлчээрийн даацын хэтэрч байгааг харуулж байна. Бүсээр авч үзвэл Хангайн бүсэд 100 га хадлан бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 62 толгой мал ногдож энэ улсын дундаж болон бусад бүстэй харьцуулахад өндөр байна.

**III.2. Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж.** 2004 онд улсын хэмжээгээр тэжээлийн нэгжид шилжүүлснээр 464.2 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн нь 2003 оныхоос 0.2 хувиар буюу 0.8 мянган тонноор дутуу байна. Бэлтгэсэн тэжээлийг нэр төрлөөр авч үзвэл байгалийн хадлан, ногоон тэжээл өмнөх оныхоо хэмжээнд болон бага зэрэг өссөн бол бэлтгэсэн сүрэл, гар тэжээл, дарш, эрдэс тэжээл буурсан байна. Тухайлбал 2004 онд 850.5 мянган тонн байгалийн хадлан бэлтгэсэн нь 2003 оныхоос 1.2 хувиар буюу 0.8 мянган тонноор их байна. Энэ нь 2004 онд ихэнх нутгаар зуншлага сайтай байсан, мөн малчид өөрсдийн нөөц бололцоог ашиглан өвс, хадлан, тэжээлээ сайтар бэлтгэсэнтэй холбоотой байна. Харин Сүхбаатар, Архангай, Орхон зэрэг аймгуудад ган гачиг болсон, тариа ногоо мөндөр, хяруунд цохиулснаас зоодой, дарш бага бэлдсэн байна.

## Бэлтгэсэн тэжээл, нэр төрлөөр


МЯН.ТН

	2000	2001	2002	2003	2004	$\frac{2004}{2003}$	%
Байгалийн хадлан	689.4	831.5	767.0	840.6	850.5		101.2
Сүрэл	21.8	24.5	9.0	22.5	19.2		85.3
Ногоон тэжээл	3.8	0.9	1.3	0.5	0.5		100.0
Гар тэжээл	11.9	20.1	26.9	30.5	30.4		99.7
Бэлтгэсэн дарш	1.3	1.6	1.8	3.8	2.1		55.3
Эрдэс тэжээл	25.5	31.8	32.3	42.6	39.0		91.6
Үйлдвэрлэсэн тэжээл-бүгд, (тэж.нэгж)	357.4	438.6	411.4	465.0	464.2		99.8

Тэжээл үйлдвэрлэлтийн хэмжээ /тэжээлийн нэгжид шилжүүлснээр/ Сүхбаатар, Баян-Өлгий, Орхон, Архангай, Улаанбаатар, Говь-Алтай зэрэг 16 аймаг, хотод 2003 оныхоос 0.1-3.8 мянган тонноор буурч, харин Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Булган, Ховд, Завхан аймгуудад 0.3-8.8 мянган тонноор нэмэгдсэн байна (Хавсралт 37-39).

Зураг 15

Бэлтгэсэн хадлан



Бүсээр авч үзвэл тэжээл үйлдвэрлэлтийн хэмжээ /тэжээлийн нэгжээр / хангай, зүүн бүсэд 2003 оныхоос 1.0-4.3 мянган тонноор буюу 1.3-3.2 хувиар нэмэгдэж, харин баруун, төвийн бүс болон Улаанбаатар хотод 1.8-3.4 мянган тонноор буюу 3.2-9.7 хувиар буурсан байна.

Үйлдвэрлэсэн тэжээлийн бүтцийг авч үзвэл хүчит, бүдүүн тэжээлийн эзлэх хувь 2003 оныхоос 0.1-0.5 пунктээр өсч, харин шүүст болон бусад тэжээлийнх 0.2-0.4 пунктээр буурсан байна.

## Үйлдвэрлэсэн тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж

	2000	2001	2002	2003	2004
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Хүчит	0.9	1.0	0.6	1.0	1.1
Шүүст	0.1	0.1	0.2	0.4	0.2
Бүдүүн	88.5	87.0	84.7	82.9	83.4
Бусад	10.5	11.8	14.4	15.7	15.3
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэж.нэгж, кг	5.8	8.8	9.1	10.1	9.5

2004 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд 9.5 кг тэжээл ногдож байгаа нь 2003 оныхоос 0.6 кг-аар бага байна. Энэ нь нийт малыг 4.8 хоног тэжээх нөөцтэй гэсэн үг юм.

## IV. ТЭЖЭЭВЭР АМЬТАД

2004 онд 17.2 мянган гахай, 177.4 мянган шувуу, 634 цаа буга, 402 илжиг, 839 бүл зөгий тоологдсон ба 2003 оныхоос гахайн тоо 3.5 мянгаар, шувууны тоо 86.8 мянгаар өсчээ.

## Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөн үржүүлдэг өрхийн тоо

	2000	2001	2002	2003	2004	2003/2004	
						%	зөрүү
Гахай (мян.тол)	14.7	14.8	13.3	13.7	17.2	125.1	3.5
Шувуу (мян.тол)	89.1	54.3	61.6	90.6	177.4	195.8	86.8
Цаа буга	680	644	652	612	634	103.6	22.0
Илжиг	890	778	307	320	402	125.6	82.0
Зөгий (бүл)	1530	1007	1177	1047	839	80.1	-208.0
Туулай	48	32	73	225	257	114.2	32.0
Гахайтай өрхийн тоо (мян.)	2.6	2.4	1.8	1.8	2.0	109.7	0.2
Шувуутай өрхийн тоо(мян.)	1.6	1.9	1.4	1.5	1.7	114.1	0.2

2004 онд гахайтай өрхийн тоо 2003 оныхоос 9.7 хувиар, шувуутай өрхийн тоо 14.1 хувиар өссөн байна. Өсгөн үржүүлж байгаа гахайны 51.5 хувь нь Төвийн, 32.5 хувь нь Хангайн бүсэд, шувууны 84.4 хувь нь Улаанбаатар хотод, 11.1 хувь нь төвийн бүсэд ногдож байна (Хавсралт 41-43).

Гахайтай өрхийн тоо 2003 оныхоос 0.2 мянгаар, шувуутай өрхийн тоо мөн 0.2 мянгаар тус тус өслөө.

## V. СУДАЛГАА

1989-2004 оны хоорондох малын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг тооцож үзвэл:

Хүснэгт 32

### Малын тоо

Он	Нийт малын тоо, мян.тол
1990	25856.9
1991	25527.9
1992	25694.1
1993	25174.7
1994	26808.1
1995	28572.3
1996	29300.1
1997	31292.3
1998	32897.5
1999	33568.9
2000	30227.5
2001	26075.3
2002	23897.6
2003	25427.7
2004	28027.9

1990-2004 оны хоорондох малын тоог хронологийн дунджийн аргаар тооцоход

$$\bar{y} = \frac{y_1 + y_2 + \dots + y_{n-1} + y_n}{n-1} = \frac{391406.4}{14} = 27957.6$$

**1990-2004 оны хоорондох 15 жилд малын тоо нь дунджаар 27957.6 мянга байжээ гэсэн дүн гарч байна.**

1999-2004 оны хоорондох 6 жилийн малын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийн тооцоог дараахь хүснэгтээр харуулав.

Хүснэгт 33

### Малын тооны динамик тооцоо

Онууд	Малын тоо, мян.тол	Абсолют цэвэр өсөлт	Хэлхээ өсөлтийн хурд (%)	Хэлхээ цэвэр өсөлт, бууралтын хурд (%)	Цэвэр өсөлтийн нэг хувьд ногдох утга
2000	<b>30227.5</b>	-	-	-	-
2001	<b>26075.3</b>	-4152.2	86.3	-13.7	302.3
2002	<b>23897.6</b>	-2177.7	91.6	-8.4	260.8
2003	<b>25427.7</b>	1530.1	106.4	6.4	239.0
2004	<b>28027.9</b>	2600.2	110.2	10.2	254.3

Дээрх хүснэгтээс харахад **2004 онд малын тоо 2003 оныхоос 2600.2 мянган толгойгоор буюу 10.2 хувиар өсч, өсөлтийн 1.0 хувьд 254.3 мянган толгой мал ногдож байна.**

1999 оноос хойших малын тооны өсөлтийн дундаж хурдыг тодорхойлбол:

$$\bar{K} = \sqrt[4]{0.863 * 0.916 * 1.064 * 1.102} = \sqrt[4]{0.927} = 0.981 \text{ буюу } 98.1\% \text{ гарч байна.}$$


**Эндээс харахад 2000 оноос хойш малын тоо жилд дунджаар 1.9 хувиар буурч байсан байна.**

### Динамик хандлагын шинжилгээ /прогнозчлол/.

Эдийн засгийн аливаа үзэгдлийг динамикаар судлах үед түүний хөгжлийн ерөнхий зүй тогтол буюу динамик чиг хандлагыг тодорхойлох шаардлага тавигддаг. Монгол улсын малын тооны өсөлтийн чиг хандлагыг тодорхойлох, түүнчлэн дараагийн 7 жилийн прогноз боловсруулахын тулд динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлж тооцоо хийх аргыг ашиглаж болох юм. Ингэхдээ 1990-2004 оны хооронд динамик хандлагын шинжилгээг хийлээ. Динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх арга гэдэг нь судлагдаж байгаа түвшингүүдийг хугацаанаас хамаарсан функц гэж үзээд динамик эгнээний өгөгдсөн түвшингүүдийг бага хэлбэлзэл бүхий түвшингүүдээр солих арга юм. Динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх аргыг ашиглан 1990-2004 онуудад том малын зүй бус хорогдол, ган зуд зэрэг бусад хүчин зүйлийн нөлөөлөлгүй байсан бол малын тоо толгой ямар түвшинд хүрэх байсан бэ, мөн цаашид дээрхи хүчин зүйлүүд нөлөөлөхгүй, байгаль цаг уурын хүндрэл гарахгүй байвал малын тоо толгой 2005-2010 онуудад хэдэн саяд хүрэхээр байна нь вэ гэдгийг гаргаж үзлээ. Бидний авч үзэж байгаа динамик эгнээг графикаар дүрсэлж үзэхэд дараахь хэлбэртэй байна.

Зураг 14

### Малын тооны динамик хандлага



1990 оноос хойшхи 15 жилийн малын тооны бодит утга дээр тулгуурлан шулуун шугамын аргыг ашиглаж тэгшитгэсэн утгыг гаргая.

Тэгштгэл нь  $y_{(t)} = a + bt$  томъёогоор илэрхийлнэ. Үүнд:

t- хугацаа



а,в- тэгшитгэлийн параметрууд

$$\begin{cases} na + b \sum t = \sum y \\ a \sum t + b \sum t^2 = \sum yt \end{cases}$$

Тэгшитгэлийн параметруудийг дараах систем тэгшитгэлээр бодох бөгөөд системт тэгшитгэлийн бодолтыг хялбарчилахын тулд  $\sum t = 0$  байхаар хугацаанд  $t$  гэсэн код өгвөл системт тэгшитгэл

$$\begin{cases} na = \sum y \\ b \sum t^2 = \sum yt \end{cases} \text{ болно.}$$

Системт тэгшитгэлийг бодож гаргахын тулд дараахь тооцооллуудыг хийе.

$Y_t$ - тэгшитгэсэн утгаар гарсан малын тоо,  $t$ - хугацаа

Хүснэгт 34

	y	T	t <sup>2</sup>	yt	y <sub>t</sub>
1990	25856.9	-7	49	-180998.3	27063.3
1991	25527.9	-6	36	-153167.4	27181.4
1992	25694.1	-5	25	-128470.5	27299.5
1993	25174.7	-4	16	-100698.8	27417.6
1994	26808.1	-3	9	-80424.3	27535.7
1995	28572.3	-2	4	-57144.6	27653.7
1996	29300.1	-1	1	-29300.1	27771.8
1997	31292.3	0	0	0.0	27889.9
1998	32897.5	1	1	32897.5	28008.0
1999	33568.9	2	4	67137.8	28126.1
2000	30227.5	3	9	90682.5	28244.2
2001	26075.3	4	16	104301.2	28362.3
2002	23897.6	5	25	119488.0	28480.4
2003	25427.7	6	36	152566.2	28598.4
2004	28027.9	7	49	196195.3	28716.5
2005	-	8	64	-	28834.6
2006	-	9	81	-	28952.7
2007	-	10	100	-	29070.8
2008	-	11	121	-	29188.9
2009	-	12	144	-	29307.0
2010	-	13	169	-	29425.1
2011	-	14	196	-	29543.1

Эндээс  $a=27889.9$

$b=118.1$  болж,  $y_t=27889.9+118.1t$  гэсэн динамик хандлагын тэгшитгэл гарлаа.

Уг тэгшитгэлийг ашиглан 1990-2004 онуудад ямар нэгэн сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл байгаагүй бол малын тоо толгой хэдэд хүрэх байж вэ, цаашид 2005-2011 онуудад хэдэд хүрэх вэ гэсэн  $y_t$  утгыг гарган авахад доорхи байдалтай байна.

Хүснэгт 35

**Малын тооны бодит болон тэгштгэсэн утга**

	$y$	$y_t=a+bt$
1990	25856.9	27063.3
1991	25527.9	27181.4
1992	25694.1	27299.5
1993	25174.7	27417.6
1994	26808.1	27535.7
1995	28572.3	27653.7
1996	29300.1	27771.8
1997	31292.3	27889.9
1998	32897.5	28008.0
1999	33568.9	28126.1
